



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/182

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд “Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж ӨВАХУСЗДТГ/202301017” барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

Д.Уранчимэг - Санхүү албаны дарга

Ш.Сангицмаа - Иргэний төлөөлөл-зөвшилцсөнөөр

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж бүрдүүлэн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ